



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/155

Ховд


Жуух бичгээр шагнах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн “Е”, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Онцгой байдлын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, галын аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, иргэд, олон нийтэд сурталчлах, иргэдийн амь нас, эд хөрөнгийг галын түймрийн аюулаас хамгаалах үйлсэд хувь нэмэр оруулан ажиллаж буй хавсралтад дурдсан нэр бүхий (6) алба хаагчдын хөдөлмөр, зүтгэлийг өндрөөр үнэлж, аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан алба хаагчдад 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож, урамшуулал олгохыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Б.Алтанбадралт)-д зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА

Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 19-ний өдрийн
А/155 дугаар захирамжийн хавсралт



ЗАСАГ ДАРГЫН “ЖУУХ БИЧИГ”-ЭЭР
ШАГНУУЛСАН АЛБА ХААГЧДЫН НЭРС

№	Овог нэр	Одоо ажиллаж байгаа газар	Албан тушаал
1	О.Учрал	Онцгой байдлын газар	Шуурхай удирдлага зарлан мэдээлэх тасгийн дуудлага хүлээн авагч, дэд ахлагч
2	Б.Отгонбаатар	Онцгой байдлын газар	Техник, хэрэгсэл хөдөлмөр хамгаалал хариуцсан мэргэжилтэн ахмад
3	П.Бямбадорж	Онцгой байдлын газар	Шуурхай удирдлага зарлан мэдээлэх тасгийн дарга, дэд хурандаа
4	Б.Энхтөр	Онцгой байдлын газар	Эрэн хайх, аврах ангийн аврагч жолооч, холбоочин ахлах ахлагч
5	Т.Балжинням	Онцгой байдлын газар	Гал түймэр, унтраах аврах 48 дугаар ангийн аврагч гал сөнөөгч ахлах ахлагч
6	Ч.Мөнхжаргал	Онцгой байдлын газар	Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, дэслэгч

-оОо-